

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№22/561

ШУС, НУС

2021

**“БАЛДОРЖ” ШАГНАЛТ НИЙТЛЭЛҮҮДИЙН ГАРЧИГТ ХИЙСЭН  
АЖИГЛАЛТ**

Д.Цэнд\*

\*СУИС-ийн РТМУС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш

**Түлхүүр үгс:** Гарчиг, гарчгийн үүрэг, гарчигт тавигдах шаардлага, Балдорж шагналт бүтээлүүд

Гарчиг нь сонин хэвлэлийн хөгжлийн түүхэнд харьцангуй хожуу үүсжээ. Анхны сонин хэвлэл огт гарчиггүй, мэдээллийн хуудас, зарын цаас хэлбэрээр гарсан байдаг. Яваандаа мэдээллийг төрөлжүүлэх, ангилах шаардлагын улмаас хэзээ, хаана, юу болсноор нь гарчиг өгч эхэлжээ. “XVI зууны үеийн сонинд мэдээнүүдийг багцалж хотын нэр, үйл явдлын болж өнгөрсөн өдөр судраар нь гарчиглаж өгдөг байв” (Ч.Чойсамба, 2003). Гарчиг бол сэтгүүлчийн ажлын онцгой чухал хэсэг болохоор эх бичвэрт сайн гарчиг олох нь амаргүй, төвөгтэй ажил байдаг. Сайн гарчигтай эх бичвэрүүдийн талаар судлаач “Манай сэтгүүл зүйн практикт шаардлага хангасан сайн гарчиг цөөнгүй бий. Тухайлбал, “Одос урамдах хязгаар”, “Парис хол боловч ойр мэт” /Л.Түдэв/, “Далай ээж маань “цаазын тавцанд”, “Хүр хорхой үржүүлж, хөвөн тарих хүмүүсээ яах вэ?” /Ц.Балдорж/, “Чивчимээгүй Туул” /Ж.Мягмарсүрэн/ (М.Зулькафиль, 2012) гэжээ. Мөн

сайн гарчгийн жишээнд байнга дурсагддаг “Далай ээж маань “цаазын тавцанд”, “Зарлигаар дархалсан ууланд зэрлэгээр халдах эрх олгожээ” зэрэг гарчгийн зохиогчид тухайн үед “Үнэн” сонины эрхлэгч Л.Түдэв гуайтай зөвлөлдөж өгсөн гэдэг” (М.Зулькафиль, 2012) гэснээс харахад гарчигт зөвхөн бичигч санаа тавих биш тухайн редакц анхаарал хандуулдаг нь харагдана.

Монголын чөлөөт хэвлэлийг хөгжүүлэх, нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх зорилготойгоор 2008 онд байгуулагдсан “Балдорж” сан жил бүр Монголын сэтгүүл зүйн шилдэг нийтлэл, нэвтрүүлэгт “Балдорж” шагнал олгодог. Шагнал авсан сонин, сайтын нийтлэлийн гарчиг нь, товч, тодорхой, цөөн үгэнд агуулгыг багтаасан байх сэтгүүл зүйн шаардлагыг хангаж байгаа эсэхийг энэхүү өгүүллээр тодруулахыг зорив. Ингэхдээ 1987 онд тухайн үеийн сонины шилдэг гарчгуудтай харьцуулан судлав.

“Гарчиг” нь монгол хэлэнд төвөд хэлнээс орж ирсэн монголжсон харь үг бөгөөд “Ном өгүүлэл зэргийн агуулгыг илтгэсэн товч нэрийдэл” (О.Сүхбаатар, 1999) хэмээн

тайлбарлажээ. Монгол хэлний тайлбар толиудаас цааш нягтлан үзвэл, “Ном хэвлэл бичиг зохиолын дотор багтаж орсон зүйлийн хураангуй томъёог хэлнэ” (Л.Болд, 2008), “I. Зохиолын агуулгын хураангуй нэр, II. Бичиг зохиолын өмнө буюу хойно бичсэн агуулгын хураангуй нэрсийн жагсаалт” (Ц.Норжин, 1999), “Ном хэвлэл бичиг зохиолын дотор багтаж орсон зүйлийн нэрийн хураангуй товъёг” (Я.Цэвэл, 1966) гэсэн бол Сэтгүүл зүйн судлаач, эрдэмтэд гарчгийн талаар “Хүн бүр дуудуулах нэртэй байдаг шиг сонины нийтлэл бүр өөрийн гарчигтай байдаг” (Ч.Чойсамба, 2010), “Нүд бол сэтгэлийн толь, яг түүнтэй адилхан нийтлэл, нэвтрүүлгийн гарчиг нь агуулгын толь болж байдаг. Гарчиг бол агуулгыг тодорхойлон гаргаж, тодруулан илэрхийлж байдаг нийтлэлийн амин чухал элемент мөн” (М.Зулькафиль, Л.Норовсүрэн, 1999), “Хамгийн сайн гарчиг бичвэрээс өөрөөс нь урган гарсан байх учиртай” (Ж.Батбаатар, 2007), “Гарчиг нь шуурхай, сонирхолтой, ойлгомжтой, гол санаа агуулсан, товч байна” (Д.Батжаргал, 2013) гэж бичсэн нь эх бичвэрт гарчиг ямар чухал болохыг илтгэж байна. Иймээс эх бичвэрийн гарчиг нь тухайн бичвэрийн хамгийн чухал хэсэг бөгөөд гарчигтай байснаар уншигч түүнийг уншиж, бичигч нь эх бичвэрээ уншуулах зорилгодоо хүрнэ. Сэтгүүл зүйд гарчгийг бичвэр, уншигч хоёрыг холбосон гүүр ч гэж тодорхойлдог.

Гарчиг нь сонгодог утгаараа XIX зууны эхэнд бий болсон гэж судлаачид үздэг. Энэ үед сонины эхний материалуудад л гарчиг өгдөг байсан ба манай хэвлэлд ч энэ уламжлал ажиглагддаг. Тухайлбал, 1913 онд хэвлэгдсэн “Шинэ толь хэмээх бичиг” сонины эхний дугааруудын зарим нийтлэлүүд гарчиггүй байгаа юм. 1920 онд хэвлэгдсэн “Монголын үнэн” сонин эх бичвэрүүдээ гарчигтай нийтэлж, тухайн зүйлийг тайлбарлан таниулсан, ухуулан сурталчилсан гарчиг ихээр өгсөн нь тухайн үеийн нийгмийн хөгжилтэй холбоотой. Жишээ нь, “Манай зорилго” /Монголын үнэн. 1920. №1/, “Март хэмээх наймны тухай” /Монголын үнэн. 1921. №9/, “Ардын эрх чөлөө мандтугай” /Монголын үнэн. 1921. №13/, мөн 1925 онд анх хэвлэгдсэн Монголын эмэгтэйчүүдийн сэтгүүлийн эхний дугаарууд гарчиггүй, харин 1926 оны дугаараас гарчигтай болжээ. Тодруулбал, “Хувьсгалт залуучуудын эвлэл ба эмэгтэйчүүд” /Эмэгтэйчүүдийн санал. 1926.№6/, “Эх нялхсыг хамгаалах нь” /Эмэгтэйчүүдийн эрх. 1928.№2/, “Клара Цеткин” /Ажилчин эмэгтэй. 1930.№7/ зэргээс харж болно. Гарчиг нь уншигчийг эх бичвэр лүү шууд хөтлөн, бичвэрийн талаар мэдээлэл өгнө. Зарим тохиолдолд шаардлагатай бүх мэдээллийг гарчгаас авдаг. Манай сонин хэвлэлүүдэд үг хэмнэсэн, цөөн үгээр утга санаагаа тодорхой илэрхийлсэн гарчгууд олон байдаг. Тухайлбал, “Дайны өдрийн тэмдэглэлээс” /Ц.Дамдинсүрэн/, “Өвгөн бүргэд

Соболев” /Б.Ринчин/, “Арван нэгэн мянган метр дээрээс сурвалжилсан минь” /Ч.Чимэд/, “Шар хэцийн шил дээрээс” /Л.Бадарч/, “Номин цэнхэр эрэг” /Г.Дэлэг/ зэргээс ажиглахад ойлгомжтой, сонирхолтой, анхаарал татахуйц, мэдээлэл агуулсан, товч буюу 3-6 үгэнд багтсан байх гэсэн шалгуурыг хангаж байна. Аливаа зохиол, бүтээлийн гарчиг бол тухайн эх бичвэрийн гол агуулга, мэдээлэл төдийгүй хөтөч нь байдаг онцлогтой. Гарчиг нь мэдээлэл өгөх, уншигчийг өөртөө татах, материалын ач холбогдлыг дарааллаар хуваарилах, нүүрийг чимэглэх, хэрэгтэй мэдээлэл олж авахад туслах зэрэг үүрэгтэй.

**1** 1980-аад оны сүүл үеийн эх бичвэрийн гарчиг. Сэтгүүл зүйн бүтээлд эх бичвэрийн гарчиг чухал учраас үе үеийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийн сэтгүүлч, редакторууд ч анхаарлаа хандуулан оюун бодлоо уралдуулж ирсэн байдаг. Тухайлбал, “Үнэн”, “Улаан-Од” сонин, “Монголын радио”, “Соёл урлаг”, “Эрүүл мэнд”, хөдөө аж ахуйн сэтгүүлүүдийн хариуцлагатай нарийн бичиг болон утга зохиолын нарийн бичгийн дарга нар, Шүүмжлэл, хэл найруулга зүйн зөвлөлийн эрхлэгч Ц.Сүхбаатар на-

рын албан тушаалтнууд гарчгийн сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэн, гарчигт анхаарал хандуулахыг онцгойлон анхаарч “Гарчгийн урлагт суралцъя” (“Сэтгүүлч сэтгүүл”, 1987) нийтлэл хэвлэсэн байна. “Улаан-Од” сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга Ц.Бат-Орших “Уншигчдадаа шууд хандсан гарчгийг олноор өгч баймаар санагдах юм. Тэгвэл хүлээж авах нь илүү байна” (“Сэтгүүлч сэтгүүл”, 1987), Монголын радиогийн ерөнхий редактор П.Сандуйжав “Сайн гарчгийг бараг л патент шиг хадгалж, хамгаалж байя” (“Сэтгүүлч сэтгүүл”, 1987), Шүүмжлэл, хэл найруулга зүйн зөвлөлийн эрхлэгч Ц.Сүхбаатар “Хүмүүст утгыг ойлгуулж уншуулах уу, үгүй юу гэдгийг гарчиг шийднэ” (“Сэтгүүлч сэтгүүл”, 1987), “Эрүүл мэнд” сэтгүүлийн нарийн бичгийн дарга Ш.Ванчаарай “Оносон гарчгийг олж өгнө гэдэг үнэхээр “тамын” ажил” (“Сэтгүүлч сэтгүүл”, 1987) хэмээн ярьсан байх бөгөөд дээрх хэлэлцүүлгээр 1987 оны хамгийн шилдэг гарчгийн жагсаалтыг шинэ оны анхны дугаарт түүвэрлэн нийтлэхээр шийдвэрлэж байжээ. Тус сэтгүүлийн 1988 оны №1 дугаарт нийтлэгдсэн шилдэг гарчгийг хүснэгтээс харвал.

Д/д	Бичвэрийн гарчиг	Сэтгүүлч	Үгийн тоо	Нийтлэгдсэн сонин
1	Сэтгэлийн сонсгол	Л.Нямготов	2	Үнэн
2	Сэтгэлийн атрыг хагалахгүйгээр хөгжихгүй	Н.Шарав	4	
3	Ширхгээр хурааснаа тонноор хаях уу?	Г.Жамц	4	
4	Саяыг зарж миллиардыг хэмнэх үү?	Х.Цэвлээ	4	
5	Тэжээлгэж суух нас биш	Д.Батмөнх	4	
6	Ой хөвчөө онгоцноос хараарай	Ц.Доржготов	4	
7	Жанжны нэрээр олгодог есөн рубль	С.Лочин	5	
8	5000 хуудас тодорхойлолт буюу 106 аварга	Л.Дашням	6	


9	Зарлигаар дархалсан ууланд зэрлэгээр халдах эрх олгожээ	Ш.Цэен-ойдов	7	
10	Хүр хорхой үржүүлж хөвөн тарих хүмүүсээ яах вэ?	Ц.Балдорж	7	
11	Тэрэлжийн сонет	Т.Мандир	2	Хөдөлмөр
12	Цаг нэгийг шивнэнэ	Г.Сүхээ	3	
13	Бид нэг л дэлхийтэй	О.Содномпил	3	
14	Гэргийн гэрэл гэгээ	Ц.Ганболд	3	
15	Өнгөлж мөлийлгөөд ч тус болсонгүй	Ч.Галсан	4	
16	Гангийн халуунд гандаж байгаа нь	С.Амарсанаа	4	
17	Газар ээжээ хайрлахын учир	О.Содномпил	4	
18	Олоогүй санаа, оноогүй үг	Б.Төмөртоогоо	4	
19	Дутуу нойртой долоо хоног	С.Амарсанаа	4	
20	Нас ухаан хоёрыг тань хүндэтгэе	Б.Төмөрбаатар	5	
21	Хул тэвэрч хуруу гаргаж суутал	П.Раднаасүрэн	5	
22	Малчны хоёр туйл	И.Дамбажав	3	Шинэ хөдөө
23	Цасан дундах нүүдэл суудал	Ө.Тогоо	4	
24	Өвлийн толинд өөрийгөө хараад	Т.Хүрэлхүү	4	
25	Сэтгэлийн “сүүг” эздүүлэгч	Д.Дамдиндорж	3	Улаан-Од
26	Гарааш нураасан ганц үсэг	Т.Ганди	4	
27	Нарийн ажлын бүдүүн баримжаа	Т.Чулуунхүү	4	
28	Найман зовхист хараа сунгах Нагалхаан уул	Б.Эрдэнэбаатар	5	
29	“Би” гэж бие тоох өвчин	Б.Чантуу	5	
30	Чанар чиний гарт	Д.Нямаа	3	Залуучуудын үнэн
31	Ээжтэйгээ зургаа авхуулдаг уу?	Т.Даваадорж	4	
32	Хөх тэнгэр шиг мөнх	Т.Бадарч	4	
33	Айлсалт арилж, саахалт сарнисан тухайд	С.Надмид	5	
34	Голын хоёр эргийг зэрэг харах хэрэгтэй	Д.Хатанбаатар	6	
35	Сэрэмжид хоромжгүй	Н.Цэнд	2	Утга зохиол урлаг
36	Малын хаяа тос	С.Даваахүү	3	
37	Пальтотой мод	Н.Батжаргал	2	
38	Халуун будаа	В.Батбаяр	2	Пионерийн үнэн
39	Дэлхийд ганцхан театр	Ж.Дашдондог	3	
40	Есөн сарын цас	В.Одсүрэн	3	
41	Халуун будаа	В.Батбаяр	2	
42	Үлгэр сонсоогүй үдэш	Ш.Мягмар	3	Улаанбаатарын мэдээ
43	Янгир хариулсан үхэрчин	Ч.Хүрэлбаатар	3	
44	Хорин нэгдүгээр зууны гутлын тухай яриа	Ц.Цэцэгчулуун	6	
45	Он цагийн нэвтэлсэн харгуй	Ч.Бат-Өлзий	4	Найрамдлын зам

Хүснэгт 1. 1987 оны шилдэг гарчгийн жагсаалт.

С.Лочингийн “Жанжины нэрээр олгодог есөн рубль”, Г.Жамцын

“Ширхгээр хурааснаа тонноор цацах уу?”, Т.Гандигийн “Гарааш нураасан

ганц үг”, Т.Даваадоржийн “Ээжтэйгээ зургаа авхуулсан уу?”, Н.Батжаргалын “Пальтотой мод” зэрэг сонирхолтой гарчгууд байна.



Зураг 1. 1987 оны шилдэг гарчгуудын үгийн тоо.

“Сэтгэлийн сонсгол”, “Халуун будаа” зэрэг 2 үгтэй гарчиг 5 /11%/ байгаа бол ихэнх гарчиг нь 3-4 үгэнд багтсан /3 үгтэй 12 буюу 27%, 4

үгтэй 18 буюу 40%/, хамгийн олон 7 үгтэй гарчиг 1 /3%/ байлаа.

XXI зууны нийтлэлийн гарчгууд (Балдорж шагналт бүтээлүүдийн гарчгийн жишээн дээр). “Балдорж” шагнал авсан сонин, сайтын 144 эх бичвэрийн гарчигт ажиглалт судалгаанд хамруулав. “Сэтгүүл зүйн практикт гарчгийн дээд хэмжээ нь 5-6 үгтэй байхад зохимжтой” (М.Зулькафиль, 2012), “Гүйлгэн харах төдийд уншихуйц богино өгүүлбэрээр байвал сайн. Ер нь 3-6 үгтэй байх нь илүү тохиромжтой гэж үздэг” (Ж.Батбаатар, 2007), товч, тодорхой, оновчтой байх гэсэн шалгуурыг баримтлав. Доорх хүснэгтэд хамгийн олон удаа шагнал авсан сэтгүүлчдийн 44 нийтлэлийн гарчгийг түүвэрлэн харуулав.


Д/д	Бичвэрийн нэр	Сэтгүүлч	Үгийн тоо	Нийтлэгдсэн хэвлэл
1	Эдийн засгийн салхи баруунаас зүүн тийшээ эргэв	Д.Мөнхчимэг	7	Үндэсний шуудан
2	Зорилго нь сайхан ч зохион байгуулалт нь хуучин тоосгонууд л байна	Г.Отгонбаяр	7	
3	Бодлогын өрсөлдөөн үү, тархи угаах уралдаан уу		7	
4	Эзэн бүтэн, сэтгүүлч хагас эрх чөлөөтэй сэтгүүл зүй		8	
5	Бид болон Монголын тал нутаг чамд хайртай		7	
6	Хөвч тайгад гурав хоног төөрөөд эсэн мэнд олдсон Ө.Энхзул охин	Б.Энхмарт	10	
7	Алтны өмнө Монголын хууль, төр засаг бөхийж, Ерөө гол Орхоны эмгэнэлийг давтах нь		12	
8	Сумын эмнэлгээс Өвөр монголын хараат-2 хүрсэн минь		8	
9	Эрүүл болсон цагт бол эр хүний замын хүзүү урт л гэдэг дээ	Б.Ганчимэг	11	
10	“Аав ээж хоёр”-ыгоо ганц сайхан дуулчхаад Энхбаярын шүүхээр буудуулна даа		12	
11	Ээж аав, нутаг ус, эх орон элэг зүрхэнд минь эгшиглэж байдаг юм шүү дээ		14	
12	Х.Баянмөнх: Аагтай омогтой, алдаатай хийморьтой залуу насны явдлыг байгаагаар		15	

	нь хайрлая гэж хэлэх гэсэн Мөөөө ирээгүй				
13	Уул уурхайнхны шунал Хүдэр голын амийг таслах нь	Ж.Сувдмаа	7	Өнөөдөр сонин	
14	Монголын стратегийн ордууд ард түмний мэдлээс гарчээ	Д.Оюун-Эрдэнэ	7		
15	Хятад сүлжээ буюу Монголын хар алтыг атгасан Winsway		8		
16	Найзыгаа алчихлаа гэж айхдаа хөвчид дөрвөн жил шахам бүгсэн	Д.Заяабат	9		
17	Эсэргүү Төмөр-Очирыг хэн егүүтгэв? Оросууд уу, эсвэл манайхан уу?		9		
18	Бодь мөрийн зэрэг үнэгүйдэж Библи үнэд орох цагаар	Х.Болормаа	8		
19	Монгол Улсыг чөдрийн ганцаас нь салгах хэнд ашигтай вэ?	Ш. Даваадорж	8		
20	Эзэд нь хүртэж амжаагүй төмрийг Хятад руу зөөгөөд дуусах нь	Д.Оюун-Эрдэнэ	8		
21	Шинэ төмөр зам тавих хүсэл ба шинэчлэлийн тэргүүний хясал	Т.Энхбат	8		
22	Дулдуйтын Равжаа дуулж явсан нутгийг харь хэлтнүүдийн хар тортгоор дарахаар зэхэж байна	Х.Уянга	12		
23	МИАТ-р их хэмжээний мөнгө угаасан зургаан хүнийг баривчилж цагдан хорьжээ	Г.Дэлгэрцэцэг	9		Өдрийн сонин
24	Хүүхдийн паркийн газраасаа хүүхэлдэйн театрынханд өгчихвөл яасан юм бэ, хотын даргаа	Б.Аззаяа	9		
25	Дүүгээ аврахын тулд долоон настай охин голоо тасартал тэмцжээ	Б.Цэцэгдэлгэр	9		
26	Хүүгээ тэвэрсэн ээж үхэлтэй тэмцэлдэж явсаар ОХУ-ын хил давжээ		9		
27	Замын-Үүдээр зэрлэг адуу мэт чихэлцэн дайрах Монголчуудын нэг өдөр		10		
28	Зүүн гурван аймгийн хуульгүй ардууд зээрийн сүргээ хүйс тэмтрээд дуусаж байна	Э.Хүрэлбаатар	11		
29	Би Монгол улсаа дэлхийн хамгийн том орон гэж боддог буюу Хануйн бага сургуулийн сурагчид		13		
30	Бичигтийн боомт дээр цэвдэг сэтгэлтэй Монголчуудын гарт адуун сүрэг маань өлдөж, хөлдөж тарчилсаар үхэж байна		15		
31	Миний эрээд байгаа Г.Цэвээн нэг хүн үү, хоёр өөр хүн үү	Г.Жамьян	11		
32	Өвгөнийгөө амьд хүрээд ирэх болов уу гэж 44 жил хүлээж байна		11		
33	Дэлхийн дуурийн ноён оргилуудын нэг, зууны манлай дуучин Х.Уртнасангийн унаган нутгаар	Н.Гантулга	12		
34	Баяд ястан, Баянмөнх аваргын хүү болж төрсөн нь миний буруу	Ж.Батмөнх, Г.Баярсайхан	9	Таван цагариг	

35	Задарсан атом нь дараа төрөлдөө ашиглагддаг Далай лам	Б.Ерэнтэй	7	Open door
36	Монгол хүнд цэвэр ус хэрэглэх эрхийг олгоё	Б.Солонго	7	Зууны мэдээ
37	Асуух ёстой нь асуулгүй, ярих ёстой нь ярилгүй үдэж дээ	Б.Энхцэцэг	7	Ub.life
38	Ханьдаа шүлэг зориулах багадна. Бүх амьдралаа зориулна шүү дээ	Д.Жаргалмаа	9	Хүмүүсийн амьдрал
39	200 зуун жилийн өмнө Монгол шиг байсан Японы хөгжлийн нууц юу гээч	Г.Одгарав	9	GoGo.mn
40	Хүн ялааны хооронд долоохон генийн зөрүү бий. Хэн байх нь танаас шалтгаална		11	
41	Гурван сая иргэнээ хар тугалгатай махаар хооллодог 60 сая малтай Монгол	З.Цэлмэг	10	Засгийн газрын мэдээ
42	Сайн байна уу, ноён Бонд гэсэн бол баяртай, ноён Бонд гэж хэлэх л болно	Х.Бүрэнтогтох	13	Монголын үнэн
43	Өөрийгөө үл тоон бусдын өмнөөс дуугарах нь сэтгүүлчийн үүрэг болохоос, сэтгүүл зүйн карьер хөөдөг салбар биш	Б.Алтанхуяг	15	МОНЦАМЭ
44	Танилц: Одоогоор УИХ-ын 16 гишүүн, гурван сайд, нэг дэд сайд, ЖДҮХС-гаас зээл авсан нь тодорхой болоод байна	Ч.Болортуяа	15	lkon.mn

Хүснэгт 2. “Балдорж” шагналт сонин, сайтын бүтээлүүдийн хамгийн олон үгтэй гарчгууд.

“Үндэсний шуудан” сонины сэтгүүлч Б.Ганчимэг, “Өдрийн сонин”-ы сэтгүүлч Э.Хүрэлбаатар, МОНЦАМЭ агентлагийн сэтгүүлч Б.Алтанхуяг, lkon.mn-ийн сэтгүүлч Ч.Болортуяа нарын эх бичвэрийн гарчиг хамгийн олон /тус бүр 15 үг/ үгтэй байгаа бөгөөд товч, тодорхой байх шалгуур алдагдаж гарчгаас эх бичвэрийн агуулга гол утга санаа бүрэн уншигдаж байна.



Зураг 2. “Балдорж” шагналт сонин, сайтын бүтээлүүдийн гарчгуудын нэгтгэл.

Дээрх гарчигт орсон товчилсон үгийг нэг үгээр тооцоход гарчгуудын дундаж үгийн тоо 10

байна. Энэ нь олон улсын сэтгүүл зүйн практикт хэрэглэдэг гарчгийн үгийн дундаж хэмжээнээс даруй нэг дахин их байна.

Долоогоос олон үгтэй 44 гарчигт анализ хийхийн тулд эдгээр гарчгууд товч, ойлгомжтой, сонирхолтой, анхаарал татахуйц байх шаардлагыг хангаж байгаа эсэхэд тандалт хийж, сэтгүүл зүйн судлаач доктор (Ph.D) дөрөв, сэтгүүл зүйн магистр таван хүнийг респондент болгон, гарчиг тус бүрээр асуулгын хуудас гарган тийм, үгүй хариултаар судалгаа авлаа. Респондентуудын хариултаас ажиглахад Ш.Даваадоржийн “Монгол Улсыг чөдрийн ганцаас нь салгах хэнд ашигтай вэ?” /8 үг/, Д.Заяабатын “Эсэргүү Төмөр-Очирыг хэн егүүтгэв? Оросууд уу, эсвэл манайхан уу?” /9 үг/, Б.Ганчимэгийн “Аав ээж хоёр”-ыгоо ганц сайхан дуулчаад Энхбаярын

шүүхээр буудуулна даа” /12 үг/ , Х.Бүрэнтогтохын “Сайн байна уу, ноён Бонд гэсэн бол баяртай, ноён Бонд гэж хэлэх л болно” /13 үг/ зэрэг арван гарчгийг *сонирхолгүй, ойлгомжгүй* гарчгаар, Б.Ерэнтэйн “Задарсан атом нь дараа төрөлдөө ашиглагддаг Далай лам” /7 үгтэй/, “Монгол Улсыг чөдрийн ганцаас нь салгах хэнд ашигтай вэ?” /8 үг/, Д.Заяабатын “Эсэргүү Төмөр-Очирыг хэн егүүтгэв? Оросууд уу, эсвэл манайхан уу?” /9 үг/, Б.Ганчимэгийн “Аав ээж хоёр”-ыгоо ганц сайхан дуулчхаад Энхбаярын шүүхээр буудуулна даа” /12 үг/, Х.Бүрэнтогтохын “Сайн байна уу, ноён Бонд гэсэн бол баяртай, ноён Бонд гэж хэлэх л болно” /13 үг/ зэрэг арван гарчгийг *сонирхолгүй, ойлгомжгүй* гарчгаар, Б.Ерэнтэйн “Задарсан атом нь дараа төрөлдөө ашиглагддаг Далай лам” /7 үгтэй/, Ш.Даваадоржийн “Монгол Улсыг чөдрийн ганцаас нь салгах хэнд ашигтай вэ?” /8 үгтэй/, Э.Хүрэлбаатарын “Зүүн гурван аймгийн хуульгүй ардууд зээрийн сүргээ хүйс тэмтрээд дуусаж байна” /11 үгтэй/, Б.Алтанхуягийн “Өөрийгөө үл тоон бусдын өмнөөс дуугарах нь сэтгүүлчийн үүрэг болохоос, сэтгүүл зүйн карьер хөөдөг салбар биш” /15 үгтэй/ зэрэг 15 гарчгийг *анхаарал татахгүй* гарчгаар нэрлэжээ. Эндээс үзвэл хэт нуршсан, олон үгтэй, далд утга санаа агуулсан, ойлгомжгүй гарчиг олон байгаа нь тухайн эх бичигчид гарчигт бүтээлч эрэл хайгуул, идэвх санаачилга гаргахгүй байгааг харж болно.

Сэтгүүлч Б.Ганчимэг “Балдорж” шагналыг нийт таван удаа авсан байна. Тэрээр 2009 онд Асашёорюу Дагвадоржтой “Ээж аав, нутаг ус, эх орон элэг зүрхэнд минь эгшиглэж байдаг юм шүү дээ” /14 үг/, 2010 онд Ерөнхий сайд асан С.Баяртай “Эрүүл болсон цагт бол эр хүний замын хүзүү урт л гэдэг дээ” /11 үгтэй/, 2011 онд УИХ-ын гишүүн Ц.Нямдоржтой “Аав ээж хоёр”-ыгоо ганц сайхан дуулчхаад Энхбаярын шүүхээр буудуулна даа” /12 үгтэй/, “Дархан аварга Х.Баянмөнхтэй хийсэн ”Аагтай омогтой, алдаатай хийморьтой залуу насны явдлыг байгаагаар нь хайрлая гэж хэлэх гэсэн Мөөөө ирээгүй” /15 үгтэй/ зэрэг ярилцлагаараа авч байсан. Эндээс ажиглахад сэтгүүлч Б.Ганчимэг нь ярилцлагаа эх сурвалжийн хэлсэн өгүүлбэрээс эш татан гарчиг өгдөг байна. Сэтгүүл зүйд гарчгийг эх сурвалжийн хэлсэн үгнээс авахыг үгүйсгэдэггүй ч хэт нуршуу, урт бүтэн өгүүлбэрээр нь авахыг сайшаадаггүй билээ. Харин сэтгүүлч Э.Хүрэлбаатар дөрвөн удаа “Балдорж” шагнал авсан. Тэрээр 2013 онд “Хүүгээ тэвэрсэн ээж үхэлтэй тэмцэлдэж явсаар ОХУ-ын хил давжээ” /9 үг/, 2015 онд “Зүүн гурван аймгийн хуульгүй ардууд зээрийн сүргээ хүйс тэмтрээд дуусаж байна” /11 үг/, 2017 онд “Бичигтийн боомт дээр цэвдэг сэтгэлтэй монголчуудын гарт адуун сүрэг маань өлдөж, хөлдөж тарчилсаар үхэж байна” /15 үг/, 2018 онд “Замын-Үүдээр зэрлэг адуу мэт чихэлцэн дайрах Монголчуудын нэг өдөр” /10 үг/ зэрэг бүтээлүүдээрээ шагнал



авсан. Э.Хүрэлбаатар нь шаардлагатай бүх мэдээллээ гарчгаараа илэрхийлдэг онцлогтой бөгөөд үүнийг сэтгүүл зүй судлаачид коммуникацийн буюу харилцааны үүрэгтэй гарчиг хэмээн тодотгодог. Гэвч энэ төрлийн гарчиг нь мэдээллийг хэт нээлттэй өгснөөр уншигчийг тухайн мэдээллийг цаашид унших сонирхолгүй болгодог хэмээн үздэг.

“Балдорж” шагналт эх бичвэрийн гарчигт ажиглалт хийж, дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. 1990-ээд оноос өмнөх эх бичвэрийн шилдэг гарчгийг 2009 оноос хойших Монголын сэтгүүл зүйн шилдэг бүтээлүүдийн гарчигтай харьцуулахад гарчиг хэт олон үгтэй байх хандлага ажиглагдлаа.
2. Орчин үеийн завгүй уншигчдад гарчгаар мэдээлэл өгөх нь зүйтэй хэдий ч хэт сүржин, шүүмжилсэн, мэдээллийг шууд дэлгэж гаргасан гарчиг зонхилж байгаа нь ажиглагдав.
3. Олон буюу долоогоос олон үгтэй гарчгуудыг шинжлэх ухааны судалгааны түүврийн аргаар авч, сэтгүүл зүйн мэргэжлийн 9 /4 доктор Ph.D, 5 магистр/ респондентоос гарчигт тавигдах шаардлагаас зөвхөн ойлгомжтой, сонирхолтой, анхаарал татахуйц, товч тодорхой байх гэсэн шалгуураар асуулга авсан. Асуулгад оролцогсод олон үгтэй гарчигт сөрөг хандлагатай байгаа нь ажиглагдав.
4. Олон үгээс бүрдсэн, хэт нуршуу гарчиг өгдөг нийтлэг дутагдал

ажиглагдаж байна. Мөн эх бичвэрийн өгүүлбэрээс шууд гарчиг болгон авах, ярилцлагад эх сурвалжийн хэлсэн өгүүлбэрийг тэр чигээр нь хуулбарлан гарчиг болгох байдал түгээмэл байна. Нийт шагналт эх бичвэрүүд дотор байгаа 11 ярилцлагын гарчиг нь бүгд ярилцагч эх сурвалжийн хэлсэн өгүүлбэр байгаа нь сэтгүүлчийн эрэл хайгуул хийх, бүтээлч байх гэсэн үндсэн зарчимд нийцэхгүй байна гэж үзэж болох юм.

5. Бичвэрт гарчиг өгөхдөө зөвхөн хүний анхаарлыг татах биш, оновчтой, сонирхолтой мэдээлэлтэй, нийгэмд үзүүлэх үр нөлөөтэй, товч, тодорхой байх шаардлага урган гарч байна.
6. Гарчгийн асуудал нь сэтгүүл зүйн тулгамдаж буй асуудлын нэг болохын хувьд “Эх бичвэрийн гарчиг” гэсэн сэдвийг цаашид сэтгүүл зүйн судлаачид дэлгэрүүлэн судлах, зөвлөмж гаргах нь зүйтэй хэмээн дүгнэв.

#### Эшлэл

1. Чойсамба Ч. Дэлхийн сэтгүүл зүйн түүх. УБ., 2003., х.11
2. Зулькафиль М. Сэтгүүлчийн ур чадвар-III.УБ., 2012.х.256
3. Зулькафиль М. Сэтгүүлчийн ур чадвар-III. УБ., 2012. Х.253
4. Сүхбаатар О.Монгол хэлний харь үгийн толь.УБ., 1999. Х. 74
5. Болд. Л.Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь.УБ., 2008, х.78
6. Норжин. Ц, Ман Мөрөн. Монгол хэлний тайлбар толь. Хөх хот., 1999. х.1654
7. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.,1966.

8. Чойсамба Ч. Сэтгүүл зүйн тухай яриа. УБ., 2010.х.43
9. Зулъкафиль М, Норовсүрэн Л. Ярилцлага.УБ., 1999.х.76
10. Батбаатар Ж. Сэтгүүл зүй УБ., 2007. Х.46
11. Батжаргал Д. Зуун жил. УБ., 2013. Х.92
12. “Сэтгүүлч” сэтгүүл. 1987. №.3. х.27
13. Мөн тэнд
14. Мөн тэнд
15. Мөн тэнд
16. Мөн тэнд
17. Зулъкафиль М. Сэтгүүлчийн ур чадвар-III. УБ., 2012. Х.256
18. Батбаатар Ж. Сэтгүүл зүй. УБ., 2007. Х.47
3. “Балдорж” боть-II. 2016. УБ.
4. “Монголын үнэн” сонин. 1920. УБ.
5. “Сэтгүүлч” сэтгүүл. 1987. УБ., 1987.
6. “Сэтгүүлч” сэтгүүл.1988. УБ. №1
7. “Эмэгтэйчүүдийн эрх” сэтгүүл. 1927. УБ.
8. URL: [www.Gogo.mn](http://www.Gogo.mn) сайт
9. URL: [www.Icon.mn](http://www.Icon.mn) сайт

### Summary

The article has been intended to clarify whether the article headlines of the “Baldorj”- the prize for best article and broadcast in Mongolian journalism-winner newspapers and websites have fulfilled requirement that the article headlines should be brief, precise and with a few words. Therefore, the article headlines have been compared to newspapers best headlines of 1987.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. “Ажилчин эмэгтэй” 1930. сэтгүүл. УБ.
2. “Балдорж” боть I. 2013. УБ.